# Агуулга

**1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ ... 2**

1. Төслийн товч мэдээлэл ... 2
2. Ордын физик газарзүйн онцлог, дэд бүтэц ... 5
3. Уур амьсгал ... 5
4. Ус зүй ... 6
5. Ургамал, амьтан ... 6
6. Хүн ам, дэд бүтэц ... 6

**2. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, АЖЛЫН ГОРИМ ... 7**

1. Ашиглалтын систем ... 8
2. Уурхайн үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо ... 9
3. Уулын ажлын төлөвлөгөө, уурхайн талбайг ашиглах дараалал ... 9

**3. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 12**

**4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ НИЙТ ТӨСӨВ ... 26**

**5. ХАВСАРГАСАН МАТЕРИАЛУУД: ... 27**

# 1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

## 1. Төслийн товч мэдээлэл

***Төслийн талбайн байршил, нэр:***

- Талбайн байршил - Дундговь аймгийн Баянжаргалан сум
- Талбайн нэр – Хар тэвш
- Талбайн хэмжээ – 55.66 га
- Планшетийн дугаар - L48-84 хавтгай

**Хүснэгт 1. Талбайн булангийн цэгийн координатууд**

| Тусгай зөвшөөрлийн дугаар | Цэгийн дугаар | Өргөрөг | Уртраг | Талбайн хэмжээ, га |
|---|---|---|---|---|
| MV-007944 | 1 | 107° 42' 20.54" | 45° 41' 51.6" | 55.66 га |
| | 2 | 107° 42' 20.54" | 45° 42' 8.61" | |
| | 3 | 107° 41' 31.54" | 45° 42' 8.61" | |
| | 4 | 107° 41' 31.54" | 45° 41' 51.6" | |




Зураг 1. Хар тэвш нүүрсний ордын байршлын зураг

1964 онд В.В. Соловьев, В.И. Ермакова Хөөтийн ордод эрлийн үе шатны ажлыг явуулж нүүрсний нөөцийг С1-зэргээр 57346 мян.т, С2- 46773.0 мян.т –оор (Нөөц 1965.01.01 өдрийн байдлаар) тооцжээ.

1992-1996 онуудад Л.Мөнхтогоо Хөөтийн нүүрс-шатах занарын ордод эрэл – үнэлгээний ажлыг явуулж доорхи асуудлуудыг шийдвэрлэжээ. Мөн ордын хэмжээнд гидрогеологи, инженер геологийн нөхцлийг судалж, ордын уул техникийн нөхцлийг тогтоосон ба уул техникийн таатай нөхцөлтэй гэж үзлээ.

1982 онд эрэл-үнэлгээний ажлаар 4897.1 т/м–тэй 25 цооног, урьдчилсан хайгуулаар 12949.8 т/м–тэй 65 цооног, нарийвчилсан хайгуулаар 1284.7 т/м–тэй 20 цооног тус тус өрөмдөж ордыг нилээд сайн судалж үнэлгээг хангалттай өгсөн байна. Нүүрсний нөөцийн зэрэглэлийг тогтоохдоо ордын бүлэг, хайгуулын торын нягтрал, нүүрсний марк, тухайн нөөцийн блокийн мэдээллийн үнэмшил зэргийг харгалзан үзсэн болно. Хар тэвшийн талбайд 100x100-180м нягтралттай хайгуулын тороор, баганат өрөмдлөгөөр хайгдсан болно.

**а. Бодит (В) нөөц**

Бодитой (В)-зэргийн нөөцөд 100-280x100 -ийн нягтралттай тороор хайгдсан, нүүрсний давхраасын байршлын нөхцөл, бүтэц, чанар тоо ,хэмжээ нь өрөмдлөг болон каротажийн судалгаагаар тогтоогдож, давхраас дахь чулууны үеийг ялгасан, нүүрсний чанарыг лабораторийн нөхцөлд тогтоосон, нүүрсний технологийн төрөл ялгагдсан, петрографийн судалгаагаар нүүрсний микро-компонентийн харьцаа судлагдсан, хайгуулын шугам дахь цооногууд, 1м-ийн ижил зузааны шугамаар хязгаарлагдсан блок дахь нүүрсний нөөцийг хамааруулла. В зэргээр нийт -4327.18 мян.тн

**б. Боломжит (С) нөөц**

Боломжит (С)-зэргийн нөөцөд 100-280x100 -ийн нягтралттай тороор хайгдсан, нүүрсний давхраасын байршлын нөхцөл, бүтэц, чанар тоо ,хэмжээ нь өрөмдлөг болон каротажийн судалгаагаар тогтоогдож, давхраас дахь чулууны үеийг ялгасан, нүүрсний чанарыг лабораторийн нөхцөлд тогттоосон хайгуулын шугам дахь цооногууд, 1 м-ийн ижил зузааны шугам, тектоник хагарлаар хязгаарлагдсан блок дахь нүүрсний нөөцийг хамааруулла. Боломжтой С зэргээр нийт -59.62 мян.тн нөөц тооцоолов.

Ордын талбайд нийт 4386.8 мян. тн нүүрсний нөөцийг үйлдвэрийн зэргээр тооцсон. Хөөтийн ордын зүүн хойд хэсгийн талбайд гүйцэтгэсэн нарийвчилсан хайгуулын ажлаар тооцсон нийт нөөцийн 4104.88 мян.тн-ыг эдийн засгийн үр ашигтай, 281.92 мян.тн-ыг тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай нөөцийн ангилалд хамааруулсан байна. Хар тэвшийн ордын техник-эдийн засгийн үндэслэлийг ордын бодитой (В) нөөцөд тулгуурлан боловсруулах боломжтой гэжээ.

**Хүснэгт 2. Хар тэвшийн нүүрсний ордын геологийн нөөцийн тооцоо**

| Дэс дугаар | Давхраасын дугаар | Нүүрсний төрөл | Нөөцийн зэрэг / мян.тн-оор/ | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | A | B | C | B+C |
| 1 | I | Эрчим хүчний | - | 222.3 | 59.62 | 281.92 |
| 2 | II | Эрчим хүчний | | 4104.88 | - | 4104.88 |
| Эдийн засгийн | | ашигтай | | 4104.88 | | 4104.88 |
| | | Тодорхой нөхцөлд үр ашигтай | | 222.3 | 59.62 | 281.92 |
| Ордын нийт нөөц | | Эрчим хүчний | | 4327.18 | 59.62 | 4386.8 |

Зураг 2. Төслийн талбайн байршлын зураг




Хар тэвш чулуун нүүрсний орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт харъяалагдах ба Улаанбаатар хотоос зүүн урагш 340 км, Чойроос баруун урагш 100 км, Мандалговь хотоос зүүн урагш 130 км, Баянжаргалан сумаас 25 км-т оршино. Улаанбаатар-Замын Үүдийн төмөр зам, авто машины хатуу хучилттай замаас 90 км, өндөр хүчдэлийн шугамаас 45 км зайтай оршдог. Тусгай зөвшөөрлийн талбай нь манай улсын дэд бүтэц сайтай дүүрэгт оршино.

## 2. Ордын физик газарзүйн онцлог, дэд бүтэц

### 1. Физик газарзүй, геоморфологи

Төслийн талбай нь Төв Монголын өмнөд хэсэгт хамаарагдах ба гадаргуу нь жижиг толгод хотгор гүдгэртэй тэгш тал газар болно. Хар тэвшийн тусгай зөвшөөрлийн талбай байрших Хөөтийн нүүрс-шатах занарын орд газар нь Монгол орны хээр талын бүс нутагт байршина. Засаг захиргааны хувьд Дундговь аймгийн Баянжаргалан суманд харъяалагдах ба геоморфологийн хувьд жижиг толгод, ухаа гүвээ, хотгор, гүдгэрийн хэв шинжийг хадгалсан. Орд хойд, баруун хойд талаараа намхан уулархаг толгод зонхилох бөгөөд өгөршилд бага орсон бялхмал чулуулагуудтай. Өмнөд, баруун өмнөд хэсгээрээ жижиг хагарлаар үүссэн, бага зэрэг өргөгдсөн дэл, толгодуудыг нийтэд нь авч үзвэл синклиналь, брахисинклиналь хэлбэрийн бүтцийг үүсгэсэн байна. Энэ хотгорт байгаа хамгийн өндөр цэг нь далайн түвшингээс 1258,2м өндөр орой бүхий Хар тэвш уул.

## 3. Уур амьсгал

Цаг уурын хувьд Төв Монголын эрс, тэс уур амьсгалтай нутагт байрлах ба өвлийн улиралд дунджаар -16°-31°C хэмийн хүйтэн, зуны улиралд дунджаар +20°-25°C хэмийн халуун байдаг. Жилд унах хур тунадасны дундаж хэмжээ 205-350 мм, хавар, намрын улиралд хүчтэй салхи элбэг гарах ба хүч нь 15-20м/сек хүрнэ. Салхины чиглэл нь баруун, баруун хойт зүгээс зонхилон салхилна.

Энгэр-ус, Хавиргын худгууд хайгуулын талбайгаас 1-8 км зайтай байдаг. Шатдаг занар, нүүрс, нефть агуулсан хурдсанд агуулагддаг ус эрдэсжилт ихтэй байдаг учир ундны усны шаардлага хангадаггүй эрдэсжилт ихтэй байдаг..

Энэ бүс нутагт хүн ам сийрэг суурьшин дан ганц мал аж ахуй эрхэлдэг. Улаанбаатар – Замын- Үүдийн төмөр зам, авто машины хатуу хучилттай замаас 90км , өндөр хүчдлийн шугамаас 45 км зайтай оршдог. Тусгай зөвшөөрлийн талбай нь манай улсын дэд бүтэц сайтай дүүрэгт оршдог.

## 4. Ус зүй

Судалгаагаар газар дорхи усны статистик түвшин 5.8м, динамик түвшин 9.0м , газар дорхи усны ундарга 0.5  л/сек болохыг тогтоосон байна. Хөөтийн  ордын орчимд тархсан газар доорхи усны химийн найрлага нь хлор сульфатын ангийн, натри-калийн бүлгийн ус зонхилох бөгөөд усны эрдэсжилтийн хэмжээ 3.1-3.5г/л, ерөнхий хатуулаг 52.7-57.62мг-экв, pH 15.6-16.9 мг-эка байна.Шинжилгээний дүнгээс үзэхэд эрдэсжилт ихтэй давслаг, хатуулаг их илэрч байгаа нь бетонон эдлэлд тохиромж муутай, унд ахуйн хэрэгцээнд тохирохгүй.

## 5. Ургамал, амьтан

Хойд говийн цөлөрхөг хээрийн мужийн монгол өвст, монгол өвс-хазаар өвст говирхог хээр боловч монгол өвст-таанат, монгол өвст-бударганат хээрийн бүсэд багтана. Ус чийг багатай, салхитай учир ургамлын бүрхүүл сийрэгдүү байдаг. Харгана, бударгана зэрэг бутлаг ургамал, таана, хөмөл, монгол өвс, хазаар өвс, шарилж, ерхөг зэрэг нэг наст болон олон наст ургамал ургадаг.

Амьтны хувьд туурайтнаас хамгийн их тархсан нь цагаан зээр бөгөөд намартаа нүүдэллэн ирдэг. Жигүүртнээс сар, элээ, хэрээ, тогоруу, ногтруу, шаазгай, хэвлээр явагчидаас могой, гүрвэл, мэрэгчдээс шар сүүлт, алаг даага, тарвага (маш бага), махчин амьтдаас үнэг, хярс зэрэг тохиолдоно.

## 6. Хүн ам, дэд бүтэц

Улаанбаатар хотоос зүүн урагш 300км, төмөр замын зангилаа Чойр хотоос баруун урагш 110км, аймгийн төв Мандалговь хотоос зүүн хойш 130км, Налайх-Замын Үүдийн хатуу хучилттай авто замаас 110кмөнгөрнө. Ашиглалтын талбайд хүн ам байнга суурьших төв газар байхгүй. Хар тэвшийн нүүрсний уурхай нь Дундговь аймгийн Говь-Угтаал, Өндөршил, Гурван сайхан, Цагаан дэлгэр, Дэрэн, Дэлгэр цогт зэрэг сумдын хүн ам олноор суурьшсан газар Баянжаргалангаас 25км зайд оршино.

## 2. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, АЖЛЫН ГОРИМ

Уурхайн- Жилийн хүчин-чадал

Техник-эдийн засгийн үндэслэлийг хийж гүйцэтгэхдээ ордын хүчин чадлыг 0.5 сая.тн-оор хийж гүйцэтгэсэн боловч манай компани 2023 онд үүсээд байгаа цар тахал, хилийн нэвтрүүлэх чадвар зэргээс шалтгаалан төлөвлөсөн нүүрсээ бүрэн гүйцэд олборлох боломжгүй болж байна.

Уулын ажлын горим

Ил уурхай нь уулын ажлыг жилд 6-р сарын 1-ээс 12-р сарын 31 хүртэл ажиллуулахаар төлөвлөлөө. Жилд ажиллах хоногийн тоо 184 байна.

Уулын ажлыг 12 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллахаар сонголоо.

Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу жилд ажиллах хоног болон, уурхайн ажиллах горимыг хүснэгт 3-т үзүүллээ

**Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим**

| № | Үндсэн ажиллагаа | Хэмжих нэгж | Уурхайд |
|---|---|---|---|
| 1 | Хуанлийн өдөр (06.01-12.31) | Хоног | 184 |
| 2 | Баяр ёслолын амралт | Хоног | 4 |
| 3 | Цаг агаарын саатал | Хоног | 10 |
| 4 | Жилд ажиллах хоног | Хоног | 170 |
| 5 | Хоногт ажиллах ээлж | Ээлж | 2 |
| 6 | Ээлжийн үргэлжлэх хугацаа | Цаг | 12 |

**Хүснэгт 4. Процессууд ба тоног төхөөрөмжийн ажиллагааны ажлын горим**

| д/д | Процессын нэр | Тоног төхөөрөмж | Гори |
|---|---|---|---|
| 1 | Экскаваци | Экскаватор | Хоногт 2 ээлж |
| 2 | Тээвэр | Автосамосвал | Хоногт 2 ээлж |
| 3 | Овоолго | Бульдозер, утгуурт ачигч | Хоногт 2 ээлж |

## 1. Ашиглалтын систем

Хар тэвшний нүүрсний ордыг ил уурхайн аргаар автотээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр олборлож байна.

Гидравлик экскаватор-автосамосвалын хослолоор ашиглах. Олборлолтын хэсгүүд рүү шилжих ажиллагаа хялбар, уурхайн зохион байгуулалтанд уян хатан байх боломжийг бүрдүүлдэг. Гидравлик экскаватор, автосамосвалын хослол нь налуу болон босоо уналтай, нийлмэл давхаргатай ордод ашиглахад хамгийн тохиромжтой хувилбар байдаг бөгөөд уг хослолыг төрөл бүрийн нөхцөлтэй ордуудад түгээмэл хэрэглэдэг тул төсөлд гидравлик экскаватор-автосамосвалын хослолоор ашиглаж байна.

***Доголын өндөр*:**Нүүрсний хаягдал, бохирдлыг бага байлгах, ухаж ачих тоног төхөөрөмжийн ажиллах нөхцөл зэргийг үндэслэн ил уурхайн ажлын доголын өндрийг $H_д$= 5м

***Ажлын бус доголын өндөр*:**Уурхайн ажлын доголыг цаашид С –зэрэглэлийн нөөцийг ашиглах бөгөөд, ил уурхайн хүрээ хязгаарт С –зэрэглэлийн нөөцийг ашиглалт явуулах үед ажлын доголуудыг нэгтгэн ажлын бус догол үүсгэнэ. Ажлын бус доголыг ажлын 2 догол нэгтгэн үүсгэсэн ба өндөр нь 10 м байсан.

***Ил уурхайн ерөнхий хажуугийн өнцөг:*** Ил уурхайн хажуугийн өнцгийг ордын чулуулгийн физик, механик шинж чанар мөн ижил төстэй уурхайн (Багануур, Шивээ-Овоо, Цагаан Овоо) ерөнхий налууг үндэслэн тогтоосон. Ил уурхайн зохиомжлолоор ил уурхайн ерөнхий хажуугийн өнцөг дунджаар 40-45$^0$ байна.

***Ажлын доголын хажуугийн өнцөг:*** Ажлын доголын хажуугийн өнцгийг чулуулгийн шинж чанараас хамааруулан хөрс, нүүрсний доголд $\alpha_д$=70$^0$ байхаар ажилласан.

***Ажлын талбайн өргөн:*** Ажлын талбайн хамгийн бага өргөн 30 м, хэвийн өргөн 50 м байна. Траншей нэвтрэлтийн өргөн түүнд ажиллах техникийн аюулгүй ажилгааг тооцон 30 м-ээр нээж явсан.

**Хүснэгт 5. Ил уурхайн үндсэн хэмжээс**

| № | Үзүүлэлт | Нэгж | Хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Ил уурхайн ажлын доголын өндөр | м | 5 | |
| 2 | Ил уурхайн ажлын бус доголын өндөр | м | 10 | С- нөөцийг ашиглалт явуулах үед 2 догол |
| 3 | Ажлын доголын хажуугийн өнцөг | град | 60-70° | |
| 4 | Ажлын бус доголын хажуугийн | град | 60-70° | Сэвсгэр хурдсанд-50° |
| 5 | Ажлын талбайн өргөн | м | 50 | |
| 6 | Траншейн өргөн | м | 30 | |
| 7 | Траншейн налуу | % | 70 | |

## 2. Уурхайн үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

Хар тэвш уурхайн нүүрсний блокийн дундуур шавар хөрсний нимгэн зузаан үеүд ихтэй ашиглалтын үед бохирдол хаягдал их гардаг тул шанаганы шүдэнд нэмэлт хусуур суулгаж дээрх асуудлыг зохих хэмжээнд шийдвэрлэж 2009 оноос ашиглаж МУ-ын зөвлөх инженер Ц.Нанзад, МУ-ын мэргэшсэн инженер С.Ганбат нарын **“Нүүрсний давхаргаас шавар, улууны үеийг ялгах хэрэгсэл”**-ийг санаачлан бүтээж Монгол улс ашигтай загварын гэрчилгээнд 2011-10-26 өдөр бүртгүүлж авсныг энхүү төслийн хаягдал бохирдлын тооцоонд ашиглаж байна.

### 1. Нүүрсний хаягдал, бохирдлын тооцоо

Уурхайн хил хязгаар доторх нүүрсний давхаргын урт, өргөн нүүрсний давхраасын дундах хоосон чулуулаг, шаврын үеүд бохирдохоор тооцоолов.

**Хүснэгт 6. Нийт хаягдал, бохирдлын хэмжээ**

| № | Хаягдал, бохирдлын ангилал | Хаягдлын хэмжээ, % | Бохирдлын хэмжээ, % |
|---|---|---|---|
| 1 | Уул-геологийн нөхцөл | 2.35 | 3.18 |
| 2 | Ухаж ачих үед | 1.20 | 0.85 |
| 3 | Тээвэрлэлтээр | 0.50 | - |
| | **Нийт** | **4.05** | **4.03** |

## 3. Уулын ажлын төлөвлөгөө, уурхайн талбайг ашиглах дараалал

Хар тэвш ил уурхайн нүүрсний давхраас хойноосоо урагш чиглэсэн (0-6 град) уналтай, суналын дагуу нилээд урт үргэлжилсэн давхарга тул ил уурхайн талбайг нээхдээ ерөнхий

капитал 2 траншейг ашиглахаар төлөвлөсөн бөгөөд ордын уул геологи, уул-техникийн нөхцөл, нүүрсний давхраасын зузаан, уналын өнцөг зэрэг нөхцлүүд мөн дэд бүтэц, талбайн онцлог зэргээс хамааруулан уурхайн нээлтийг сонгосон.

Хар тэвш ил уурхайн ордын нүүрсний давхарга хойноосоо урагш чиглэсэн (0-15 град) уналтай, суналын дагуу нилээд урт үргэлжилсэн давхаргатай бөгөөд ерөнхий капитал 2 траншейг нээн ордыг ашиглаж эхэлсэн.

Уурхайн цаашдын ахилтын чиг нь нүүрсний давхраасын суналын дагуу хэлбэржин тогтох бөгөөд доголын фронтын чиг ахилтад перпендикуляр байхаар байна.

## 1. Уулын ажлын хөрс хуулалт болон нүүрс олборлолтын хэмжээ

Хөрс хуулалтанд DOOSAN-800 маркийн 5.2 $м^3$, HYUNDAI -520 маркийн 3.2 м3 шанаганы багтаамжтай экскаватор 2 ширхэг, нүүрс олборлолтод, DOOSAN-520 маркийн 3 м3 HYUNDAI -3000 маркийн 1.2 м3 шанаганы багтаамжтай экскаватор ашиглаж байна. Мөн зам талбай бэлтгэх, траншей нэвтрэлтийн ажил зэрэгт HYUNDAI-300 маркийн 1.1 м3 шанаганы багтаамжтай экскаватор ашиглаж байна.

## 2. Ухаж ачих ажил

Хадархаг хөрс хуулалтанд DOOSAN-800 маркийн 5.2 м3 шанаганы багтаамжтай экскаватор, өнгөн хөрс хуулалт болон нүүрсний давхарга хоорондын хөрс хуулалтын ажилд HYUNDAI 500 болон 520 маркийн 3-3,2 м3 шанаганы багтаамжтай экскаватор, Нүүрсний таац цэвэрлэгээ болон ачилтанд HYUNDAI-3000 маркийн 1,1 $м^3$ шанаганы багтаамжтай экскаватор, хөрс сийрэгжүүлэлт болон нүүрс ачилтанд HYUNDAI-4700 маркийн экскаватор ажиллаж байна.

## 3. Уурхайн тээвэр

Уурхайн хөрс болон нүүрс тээвэрлэлтийн механикжуулалтын ажлыг автосамосвалын тусламжтайгаар гүйцэтгэж байна. Хөрсийг ил уурхайн зүүн хойд талд байрлах хөрсний

гадаад болон ил уурхайн хойд талд дотоод овоолгод тээвэрлэн овоолох ба хөрс тээвэрлэлтийн дундаж зай 1.2 км байна.

## 4. Овоолгын аж ахуй

Уурхайн хөрсийг өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлж, автосамосвалаар тээвэрлэн хөрсний гадаад овоолгод хураах ба овоолгыг талбайн болон захлах хэлбэрээр бульдозерын тусламжтай гүйцэтгэсэн. Дээрх ажилд SHATUI SD16 маркийн бульдозер, болон ZL 50 маркын утгуурта ачигч ажилласан.

Овоолгын тээврийн зурвасын өргөн 25 м, доголын налуу 38° байна. Овоолгыг хур тунадас ихтэй зуны улиралд суулт гулсалт гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан. Цас мөсийг овоолгод хураахыг хориглоно. Овоолго дээрх суулт гулсалтаас сэргийлэхийн тулд суваг шуудуу татаж ажилласан.

# 3. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төсөл хэрэгжих талбай болон орчны байдал, ТЭЗҮ-тэй танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Уг төслийн байршил, техник технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн “магадлан жагсаалт” хүснэгтэнд түүний нөлөөллийн үр дагаврыг “муу”, “дунд”, “сайн” гэсэн утгуудын аль тохирохыг “х” гэж бөглөв.

**Хүснэгт 7. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах**

| Байгаль орчны асуудлууд | Нөлөөлөл байхгүй | Гол үр дагавар | | |
|---|---|---|---|---|
| | | Муу (бага) | Дунд | Сайн (их) |
| **1.Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал** | | | | |
| Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал | x | | | |
| Түүх соёлын дурсгалт газар, археологи-палентологийн олдворт газрыг эвдэхэд | x | | | |
| Усан хангамж, газрын доорх усны горимд өөрчлөлт орох | x | | | |
| **2. Төслийн шийдэл, төлөвлөөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал** | | | | |
| Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, | | | | x |
| Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон | | | x | |
| Уурхайн үйл ажиллагааны явцад гарах тоосжилтыг бууруулах асуудал хир зэрэг | | | | x |
| Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх | x | | | |
| Үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд | | x | | |
| **3. Барилга байгууламж барих, үйлдвэрийн аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал** | | | | |
| Төслийн үйл ажиллагааны үед усны нөөц хомсдох байдал | | x | | |
| Төсөл хэрэгжих үеийн хөрсний элэгдэл, эвдрэл | | | | x |
| Үйлдвэрлэлийн осол, аваар, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин | | | x | |
| **4.Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал** | | | | |
| Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, | | | x | |
| Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, | | | x | |
| Хөрсний эвдрэл, элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд | | | x | |
| Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан | | x | | |
| **5.Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)** | | | | |
| Төслийн техник технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд болон | | | | x |

| Хар тэвш MV-007944 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайд хамаарах, Төрийн захиргааны төв байгууллагаар батлуулсан, Байгаль орчны менежментийн 2023 оны төлөвлөгөөний биелэлт | | | |
|---|---|---|---|
| Д/Д | **"Биг могул коул энд энержи" ХХК-ийн хүлээх үүргийн үзүүлэлт** | **Төлөвлөсөн ажил** | **Гүйцэтгэл** |
| 1 | I. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | Тоосжилтыг бууруулахад уурхайн карьер, овоолго, зам, талбайг усалгаа хийх<br><br>Ажилчдын байрны агаарын чанарыг сайжруулах, тоосжилтыг бууруулах цэвэрлэгээ тогтмол хийх, чийгшүүлэх<br><br>Уурхайн ухалт, ачилт буулгалтын цагийг хоногийн салхины горимтой уялдуулан зохион байгуулах<br><br>Хүнд машин, механизмын засвар үйлчилгээг хийх, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ | Зам талбайн усалгааг тоноглосон машинаар, “Хар тэвш”-ын нүүрсний ил уурхайн шүүрлийн усыг ашиглан гүйцэтгэж байна.<br><br>Ажилчдын байрны агаарын чанарыг сайжруулах тоосжилтыг бууруулах зорилгоор цэвэрлэгээг тогтмол хийж гүйцэтгэж байна.<br><br>Уурхайн ухалт ачилт буулгалтыг баруун болон баруун өмнөөс үед зогсоож ажилчдын кемпрүү тоос шороо орохоос сэргийлж ажиллаж байна.<br><br>Уурхайд ажиллаж байгаа техник хэрэгслүүдийг хугацаанд нь оношлогоонд оруулж засвар үйлчилгээг цаг хугацаанд нь хийж ажиллаж байна. Мөн аудитын зөвлөмжинд заасний дагуу бүх техникүүд оношлогоонд орж агаар бохирдуулсаны төлбөрийг төлж байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | Уурхайн карьер доторх болон түүнээс гарч буй замуудыг засч сайжруулах<br><br>Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах | Уурхайн карьер доторх болон түүнээс гарч буй замуудыг автогрейдэр техник ашиглан өдөр бүр засч техникийн гэмтэлээс урьдчилан сэргийлж байна.<br><br>Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж аюулгүй ажиллагааны зааварчилгаа өдөр бүр өгч ажилуулж байна. |
| | | Ус ашиглалтын зөвшөөрөл авах, гэрээг холбогдох орон нутгийн болон бусад холбогдох байгууллагатай хийж баталгаажуулах, төлбөрийг цаг тухай бүр төсвийн дансанд оруулах | Дундговь аймгийн Байгаль орчны газартай усны гэрээ байгуулж 2023 онд 9,484,284 төгрөгний усны төлбөрийг төлсөн. |
| | | Гүний худгийг хашиж хамгаалах, хаягжуулах<br><br>Усны хэмжээ, чанарыг хянах, хяналтын цооног байгуулах<br><br>Бороо цас үерийн ус цуглуулах сан байгуулах, үерээс хамгаалах далан байгуулах талаар судлах | Гүний худгийг хашиж хаягжуулан ажилчдын ундны усны эрүүл ахуйг маш сайн мөрдөж ажиллаж байна.<br><br>Бороо цас үерийн ус цуглуулах сан байгуулах талаар судлаж өвлийн улиралд шүүрлийн усан сан байгуулах зөвшөөрлийг Баянжаргалан сумын байгаль орчны мэргэжилтэнээс авсан болно. |

| | | | |
|---|---|---|---|
| | | Ил уурхай, овоолго байгуулах талбайн үржил шимт хөрсийг хуулж, 5 м- ээс өндөргүй овоолон хадгалах | Шинээр хөрс хуулалтын ажил хийгдсэн талбай, хөрсний овоолгын талбайн шимт хөрсийг хуулж биологийн нөхөн сэргээлтэнд ашиглахаар тусад нь овоолго үүсгэсэн. |
| | | Уурхайн дотоод гадаад тээвэрлэлтийн замыг хайрган хучилттай болгох | Уурхайн дотоод гадаад тээвэрлэлтийн замыг өдөр бүр засаж сайжруулж байна. |
| | | Тогтсон маршрутын дагуу тээвэрлэлт хийх<br><br>Замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбар хийж байрлуулах<br><br>Олон салаа зам гарахаас сэргийлж байгуулсан тэмдэг, тэмдэглэгээг засч сайжруулах | Уурхайн гадуур байх шаардлагагүй замуудыг хааж зөвшөөрөгдсөн зам талбайг уурхайн шүүрлийн усаар зориулалтын усалгааны машинаар усалгаа хийж хяналт тавин ажилласан. Замын тэмдэг тэмдэглэгээг шинэчлэн байрлуулсан. /Хавсралтанд хавсаргав/<br><br>Баянжаргалан сумын мод тарих газар 250 ширхэг чацарганы мод тарьж арчилгааг 3 жил хариуцахаар болсон. |

| | | | |
|---|---|---|---|
| | | Уурхайн ажилчдын байр орчимд болон гол замуудыг дагасан мод бут тарих | |
| | | Шатах, тослох материал, ажилласан тосны хаягдлыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлэх<br><br>ШТМ, агуулах болон засварын төвийн талбайг хатуу хучилттай болгож газрын гадарга, хөрс бохирдохоос сэргийлэх<br><br>Хог хаягдлыг тухай бүрт нь ангилан зайлуулах арга хэмжээ авах | 2023 онд уурхайн засварын цэгт аюултай хог хаягдалын цэгийг стандартын дагуу байгуулж, хашаалж, хаягжуулсан болно. Энэ ажилд 3700000 төгрөг зарцуулсан болно.<br><br>Дундговь аймгийн Баянжаргалан сумын 2-р багийн даргатай 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн №04 тоот “Хог хаягдлын гэрээ”-г байгуулсан. Хог хаягдлыг тухай бүрт Баянжаргалан сумын хогийн цэгрүү тээвэрлэж байна.<br><br>2023 онд хогны төлбөрт 960000 төгрөг төлсөн байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | Хог хаягдлын талбайг хашиж хаягжуулах | Мөн хог хаягдлын талбайг хашиж хаягжуулсан болно. Энэ ажилд 1650000 төгрөг зарцуулсан болно. |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | Уурхайг тохижуулах, тосгон орчим хийгдэх нөхөн сэргээлт | Баянжаргалан сумын мод тарих газар 250 ширхэг чацарганы мод тарьж арчилгаа 3 жил хариуцахаар болсон. |
| 3 | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | Биологийн олон янз байдлын суурь судалгаа хийх<br><br>Ургамалан нөмрөг нь хуулагдах болон нөлөөлөлд өртөхгүй талбайнуудыг тодорхой болгож урьдчилан хамгаалах тэмдэглэгээ сануулга байрлуулах<br><br>Орон нутгийн захиргаатай хамтран ажиллаж тохирсон газарт ойжуулах, хөрс | Биг Могул коул энд энержи компани 2023 оноос хариуцлагатай уул уурхайн компани болох зорилтыг тавьсан бөгөөд энэ зорилтын хүрээнд Байгаль орчин аялал жуулчлалын яамны Ойн газартай 5000 ширхэг мод тарьж ургуулах санамж бичигийг байгуулсан болно. Мөн тарих мод болон бордооны гэрээг байгуулж баталгаажуулсан болно./Санамж бичиг, Модны гэрээ, Бордооны гэрээг хавсаргав/<br><br>Дундговь аймгийн Баянжаргалан сумын мод тарих талбайд Биг могул коул энд энержи компани 2023 онд 800 ширхэг хайлаас модыг амжилттай тарьсан болно. Цаашид 2 жил усалгаа бордоог хариуцаж сумын байгаль орчны ажилтанд хүлээлгэн өгөх болно. Энэ ажилд 7300000 төгрөг зарцуулав. /Зураг хавсаргав/ |

| | | | |
|---|---|---|---|
| | | хамгаалах, цөлжилтийг бууруулах арга хэмжээ авах<br><br>Мэргэжлийн байгууллагатай хамтран зэрлэг амьтдыг хамгаалах биотехнологийн арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлэх<br><br>Орон нутгийн захиргаатай хамтран ажиллаж эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх | Орон нутгийн захиргаатай хамтарч Хөөтийн булгийн эхийг шургааг модоор хашаалав. Энэ ажилд нийт 15 сая төгрөг зарцуулав. /Хавсралтанд хавсаргав/<br><br>Нөхөн сэргээлт 2024 арга хэмжээний хүрээнд Дундговь аймгийн байгаль орны газраас ирсэн саналын дагуу 0,3 га газар техникийн нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэн өгсөн. Энэ ажилд 5750000 төгрөг зарцуулсан болно.<br><br>Зэрлэг амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээний хүрээнд Биг Могул Коул энд Энержи компани 100 боодол өвс 2 тонн хужирыг Баянжаргалан сумын Байгаль орчны хамгаалагч Баярсайханд хүлээлгэн өгч зэрлэг ан амьтдад тавьж өгсөн. Энэ ажилд 1900000 төгрөг зарцуулсан болно. |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | Уурхайн нөлөөллийн бүсэд суурьшлын бүс байхгүй, малчин өрх байхгүй. | Энэхүү асуудлаар ямар нэгэн өргөдөл, гомдол гараагүй. |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | Түүх, соёлын өвийн дурсгалт зүйл илрээгүй. | Түүх, соёлын өвийн дурсгалт зүйл илрээгүй. |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө | Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах<br>Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах<br>Гал унтраах хэрэгсэлээр бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах<br>Барилга байгууламжийг газар хөдлөлийн бүсэд тохируулан хийцийг сонгох<br>Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх<br>Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр | Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгаж осол, эрсдлээс хамгаалах талаар тогтмол сургалт, үзүүлэн таниулах ажлыг байнга хийж байна. Уурхайн бүх ажилчдыг хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцсаар хангасан. |

| | | | |
|---|---|---|---|
| | | (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинэн гутал, резинэн бээлий, хамгаалалтын нүдний шил, маск) хангах.<br>Хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлийг нарийвчлан мэргэжлийн байгууллагаар тогтоолгох.<br>Тэсэрч дэлбэрэх бодисын үлдэгдэл аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх. | |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө | Ахуйн хаягдалыг ангилах дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээ авч байх | Дундговь аймгийн Баянжаргалан сумын 2-р багийн даргатай 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн №04 тоот “Хог хаягдлын гэрээ”-г байгуулсан. /Гэрээг хавсаргав./ |
| | | Хаягдал дугуй болон төмрийн хаягдалыг ангилан ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх | Аюултай хог хаягдалын гэрээг Элеменк ХХК-тай байгуулж аюултай хог хаягдал устгах төлбөр төлсөн./Гэрээ болон төлбөр төлсөн баримтыг хавсаргав/ |
| | | Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх | 2023 онд уурхайн засварын хэсэгт аюултай хог хаягдлын цэг байгуулсан. Ингэхдээ хөрсрүү аюултай хог хаягдал нэвчихээс сэргийлж зориулалтын филонк дэвсэж өгч дээр нь бетон цутгаж хашаалсан болно. /зураг хавсаргав/ |
| | | Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх | Хог хаягдалын талаар бүх инженер техникийн албаны ажилчид операторуудад сургалт орж авултай хог хаягдал болон энгийн хог хаягдалын талаар ойлголт өгсөн. |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | Орчны хяналт шинжилгээг тухайн жилд 1 удаа гүйцэтгүүлэх | Тус шинжилгээг Байгаль орчин аялал жуулчлалын яамны харъяа байгууллага болох Байгаль орчны судалгаа шинжилгээний төвөөр хийлгэсэн болно. Энэ ажилд 1090000 төгрөг зарцуулав. |
| 9 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө | Тухайн жилийн байгаль орчны менежментийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнах | Баянжаргалан сумын II Багийн ИНХ-д 2023 оны БОМТ-ийн биелэлтийн талаар тайлагнасан бөгөөд ард иргэд суманд тарьсан мод болон бусад зүйлд маш сэтгэл хангалуун байсан. |
| 10 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | Уулын бэлтгэл ажил, олборлолтын үед ажлын талбай бэлтгэх, ажлын замын сүлжээ байгуулах хөрс хуулалт хийх, овоолго байгуулах. | “Биг могул коул энд энержи” ХХК нь тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдлөг болгон үйл ажиллагааг Монгол улсын хууль журманд нийцүүлэн ажилласан. |

# 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ НИЙТ ТӨСӨВ

| № | Зардлын ангилал | Зардал, мян.төг |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | 22620,0 |
| 2 | Нөхөн сэргээлт | 200.0 |
| 3 | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ | 9600.0 |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ | - |
| 5 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 6 | Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө | 2000,0 |
| 7 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 1700,0 |
| 8 | Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр | 695,08 |
| 9 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 20000,0 |
| 10 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах | 500,0 |
| **Нийт төсөв, мян.төг** | | **57,315.08** |

Хар тэвшний нүүрсний ордын 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэнд нийт 57,315.08 мян.төгрөг зарцуулав. Энэ зардалд ус ашигласан болон худгийн барилгын зардал орсон.

## 5. *ХАВСАРГАСАН МАТЕРИАЛУУД:*

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ, холбогдох баримт
2. Тусгай зөвшөөрлийн хуулбар
3. Хог хаягдлын гэрээний хуулбар /хог хаягдал тээвэрлэж байх үеийн зурагтай/
4. Дундговь аймгийн УЦУОШТ-тэй Хамтран ажиллах гэрээний хуулбар /шинэжилгээний хариуны хамт/
5. Байгаль орчны аудит хийлгэсэн Ажил гүйцэтгэх гэрээний хуулбар, дүгнэлт, зөвлөмж
6. Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажил гүйцэтгэх гэрээний хуулбар
7. Эрдэс баялагийн мэргэжилийн зөвлөлийн дүгнэлт
8. Ашигт малтмал, газрын тосны газрын даргын тушаал
9. Уурхайг ашиглалтанд авах улсын комиссын акт
10. Хавсралт зургууд

# 4. ХАВСАРГАСАН МАТЕРИАЛУУД:

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ, холбогдох баримт
2. Тусгай зөвшөөрлийн хуулбар
3. Ойн газартай байгуулсан санамж бичиг
4. Мод худалдан авах гэрээ
5. Бордоо худалдан авах гэрээ
6. Хог хаягдлын гэрээний хуулбар
7. Аюултай хог хаягдлын гэрээ
8. Дундговь аймгийн УЦУОШТ-тэй Хамтран ажиллах гэрээний хуулбар
9. Эрдэс баялагийн мэргэжилийн зөвлөлийн дүгнэлт
10. Ашигт малтмал, газрын тосны газрын даргын тушаал
11. Уурхайг ашиглалтанд авах улсын комиссын акт
12. Хавсралт зургууд

БАТЛАВ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА Н.ГАНТУЛГА

БАТЛАВ
"БИГ МОГУЛ КОУЛ ЭНД ЭНЕРЖИ" ХХК-НЫ
ЗАХИРАЛ Б.ОТГОНБААТАР

# УС АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

2023.11.21 Дугаар 04 Мандалговь хот

**Нэг. Ерөнхий зүйл**

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны гаргасан 2023 оны 11 сарын 13–ны өдрийн 23 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын олгосон 2023 оны 11 сарын 21 –ний өдрийн А/18 дугаартай ус ашиглах зөвшөөрөл олгох тухай тушаалыг тус тус үндэслэн:

Усны нөөц ашиглуулагчийг төлөөлж Дундговь аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Батмөнх овогтой Цэрэнсугир

Ус ашиглагчийг төлөөлж Дундговь аймгийн Баянжаргалан сум, 9011225079 улсын бүртгэл, 5369223 регистрийн дугаартай "Биг могул коул энд энержи" ХХК-ны захирал Б.Отгонбаатар нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

**Хоёр. Гэрээний гол нөхцөл**

2.1. Ус ашиглах зориулалт: MV – 007944 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй нүүрс олборлоно.

2.2. Нийт ашиглах усны хэмжээ: 18812,4 $м^3$

2.2.1. Унд ахуй, $м^3$/хоног 4694,4 $м^3$

2.2.2. Шүүрлийн усны хэмжээ: 10368 $м^3$

2.2.3. Ногоон байгууламжийн усны хэмжээ: 3750 $м^3$

2.3. Усны чанар, найрлага:

2.4. Усны эх үүсвэр: Унд ахуйн хэрэглээг зөөврөөр хангана.

2.4.1. Байршил: Баянжаргалан сумын төвийн гүн өрмийн худгаас ашиглана.

2.4.2. Солбицол: *$107^0$59'42.64"* *$45^0$45'20.14"*

2.4.3. Барилга байгууламж: Байшинтай.

2.4.4. Тоног төхөөрөмжийн нэр, марк: Экскоfísico /Hyundai – R2900LC, 3000 LC/ Экскаватор /Howo 25tn/ CM-358 маркийн өрмийн машин, shantui SD16 маркийн бульдозер, утгуурт ачигч ZL50, PY-200 маркийн грейдэрийг ашиглана. Хаягдал ус: Унд ахуйн бохир усыг хөрсөнд нэвчүүлэн зайлуулна.

Стандартын шаардлага:

Хаях цэгийн байршил:

Солбилцол X-Y- Z-

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ. Усны биохимийн шинжилгээний дүнг хавсаргана.

Жинлэгдэх бодис ..........................................................................................

Органик бодис ..............................................................................................

Эрдэс бодис .................................................................................................

Хүнд металл ..................................................................................................

Аюултай бохирдуулах бодис, гр .....................................................................

2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

2.9. Усны тоолуурын төрөл, нэр, дугаар: Тоолуургүй. Мэргэжлийн байгууллагаар тоолуур баталгаажуулж, суурилуулах.

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1. дэх заалтын дагуу ажилчдын унд ахуйн хэрэгцээнд хэрэглэх 4694,4 $м^3$ усыг төлбөрөөс чөлөөлнө.

